

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХАРХОРИН СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ БҮТЭН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 12

Хархорин сум

Анхан болон давж заалдах шатны шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны нийтлэг журмын 11.2-д “Тамгын газар гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хагас, бүтэн жилээр нэгтгэн гаргах бөгөөд эхний хагас жилд явцын хяналт шинжилгээ, жилийн эцэст хяналт шинжилгээ үнэлгээ хийж тухайн шүүхэд танилцуулж Ерөнхий зөвлөлд хүргүүлж дүгнүүлнэ” гэж заасны дагуу Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Сум дундын шүүхийн тамгын газрын 2022 оны бүтэн жилийн үйл ажиллагааны хэрэгжилтийг тайлагнаж байна.

Нэг. Удиртгал

1.1 Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого, Шүүхийн захиргааны байгууллагын стратеги төлөвлөгөөнд тусгагдсан, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс тухайн жил хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн тэргүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Тус шүүх нь энэ онд 4 шүүгч, төрийн захиргааны болон үйлчилгээний 17 ажилтан албан хаагчтайгаар ажиллаж, Монгол улсын шүүхийн тухай хууль, ШЕЗ-өөс баталсан журмуудын хэрэгжилтийг ханган шүүх шүүхийн захиргааны үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулж байна. Шүүхийн тамгын газрын дарга шинээр томилогдон, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын сул 2 орон тоонд сонгон шалгаруулалт явуулах захиалга өгч 1 орон тоог журмын дагуу шилжүүлэн томилж, сул орон тоог нөхөж, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын сул орон тоонд сонгон шалгаруулалт явуулах захиалга өгч хүний нөөцийг бүрдүүлэхэд анхаарч ажиллаж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээ болон байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхээр улирал тутам төлөвлөгөө гаргаж биелэлтийг хянаж, сайжруулах, эрчимжүүлэх шаардлагатай ажил арга хэмжээг холбогдох албан тушаалтанд үүрэг чиглэл өгч гүйцэтгүүлэн, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулан зөрчилгүй ажиллалаа.

Хоёр. Үндсэн хэсэг

2.1. ШҮҮХИЙН БИЕ ДААСАН БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

2022 онд Монгол Улсын дээд шүүх болон Шүүхийн ерөнхий зөвлөлөөс санал авахаар ирүүлсэн дүрэм, журам, аргачлалын 25 төслийг ирсэн бичгээр хүлээн авч 7 төсөлд санал хүргүүлэн, санал хүргүүлсэн 7 журмын төслийн жагсаалтыг гаргаж, сан бүрдүүлж, баяжуулан ажиллаж байна.



Шүүхийн тамгын газрын төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх улирлын төлөвлөгөө гарган, хэрэгжилтийн явцыг хянаж, удаашралтай, гүйцэтгэл дутуу ажил, арга хэмжээг сайжруулах, эрчимжүүлэх үүрэг чиглэлийг холбогдох албан тушаалтанд өгч ажиллалаа.

Шүүхийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх журмын дагуу 2022 оны 07 дугаар сарын 19-нд цахим талбарт тайланг гарган хүргүүлсэн.

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргын 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 232 дугаартай тушаалаар батлагдсан зарим анхан болон давж заалдах шатны шүүхийн тамгын газрын 2022 оны үйл ажиллагаанд аудит хийх удирдамжийн дагуу 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөс 11 дүгээр сарын 01-ний өдрийн хугацаанд тус тус хяналт-шинжилгээ үнэлгээг биечлэн хийж гарсан зөрчил, цаашид анхаарах асуудлыг нийт албан хаагчдын хурал дээр танилцууллаа.



Шүүхийн байрны гадна иргэдэд зориулан иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх мэдээллийн самбар байршуулсан. Шүүхийн мэдээллийн самбарт зохих журмын дагуу мэдээллийг шинэчлэн, харьяалах сумдын /Бат-Өлзий, Баян-Өндөр, Хужирт, Өлзийт, Бүрд, Есөнзүйл, Хархорин/ ЗДТГ-ын газрын байранд шүүхийн мэдээллийн самбар байршуулан улирал тутам мэдээллийг шинэчилж шүүхийн тамгын газраас улирал тутам хэвлэн гаргадаг “Шүүхийн мэдээлэл” сэтгүүлийг сум тус бүрд шуудангаар хүргүүлэн иргэдэд хүргэж байна.




Шүүх хуралдааны зар, тоймыг шүүх хуралдааны явцыг мэдээлэх цахим системээр дамжуулан иргэдэд хүргэж, шүүхийн шийдвэр эрүү, иргэний хэргийн хөдөлгөөний программд мэдээллийг тухай бүр, үнэн, зөв, бүрэн оруулж байршуулсан. live.shuikh.mn цахим системд иргэний 167, эрүүгийн болон зөрчлийн 427 шүүх хуралдааныг бүртгэн, ажиллагаа хийгдсэн байна.


2022 оны 1-11 дүгээр сарын сар тутмын мэдээ, 1-3 дугаар улирлын мэдээ, хагас жилийн мэдээг гарган, цахим сайт болон фэйсбүүк хуудсаар дамжуулан иргэдэд хүргэж байна.



Шүүхийн цахим сайтын цэсийг шинэчилж, хэрэг, нэхэмжлэл хуваарилах ажлыг иргэдэд харагдахаар дэлгэц байршуулан шүүхийн үйлчилгээний төвийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүллээ.



Эвлэрүүлэн зуучлалын мэдээллийн самбарыг танилцуулга, утасны дугаар, эвлэрүүлэн зуучлалын хуулийн талаарх мэдээлэл бүхий тусад нь байршуулсан.



Шүүхийн цахим сайтад танилцуулга, мэдээлэл лавлагаа, эвлэрүүлэн зуучлал, шилэн данс, хэрэг хуваарилах журам, тайлан мэдээ, цахим хүсэлт, тамгын газрын үйл ажиллагааны хөтөч, Тамгын газарт хүсэлт гаргах цэсийг байршуулан иргэд мэдээлэл авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

Мөн Шүүхийн архивын үйлчилгээ, иргэд хүлээн авах цагийн хуваарь, мэдээлэл лавлагааны утас, авлигын мэдээлэл авах утас, тухайн шүүхээс эрхлэн гаргасан видео шторк, улирал тутмын цахим сэтгүүл, шүүгчийн ёс зүйн дүрэм, 2022 оны 1-11 дүгээр сарын сар тутмын мэдээ, 1-3 дугаар улирлын, хагас жилийн мэдээг хүлээн авсан болон хянан хэлэлцсэн, шүүх хуралдаанд хойшлолт, түдгэлзүүлсэн хэрэг, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны талаарх мэдээллийг байршуулж, өөрчлөгдсөн тухай бүр нь шинэчилж байна.

Иргэдэд үйлчлэх хэсэгт байршуулсан дэлгэцээр шүүх хуралдаан шууд дамжуулах нөхцөлийг хангаж, Шүүхийн ерөнхий зөвлөл, Авлигатай тэмцэх газар, Улсын дээд шүүхээс бэлтгэсэн 10 төрлийн видео шторкыг “Шүүхийн байранд мэдээлэл түгээх журам”-ын дагуу иргэдэд хүргэж байна.



Хуульд зааснаас бусад тохиолдолд шүүх хуралдаанд иргэд, байгууллагын төлөөллийг оролцуулахаар журамд заасны дагуу хүсэлт гаргасан 28 иргэнийг эрүү, иргэн, зөрчлийн хэргийн хуралдаанд сонирхогчоор оролцох боломжийг хангаж оролцууллаа.

Шүүхийн үйл ажиллагааг иргэд, байгууллагад нээлттэй, ил тод байдлыг ханган "Хуульчийн про боно өдөр-2022" өдөрлөгийг 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдөр "Манлай тод" хүнсний худалдааны төвд "Нээлттэй шүүх" сэдвийн дор зохион байгуулж, 240 гаруй иргэнд, харьяалах сумдад "Нээлттэй шүүх" арга хэмжээг 5 удаа 10 суманд зохион байгуулж, 160 гаруй иргэнд, Хархорин сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран "Хуулийн байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг 11 дүгээр сарын 08-ны өдөр зохион байгуулж, 100 гаруй иргэдэд мэдээлэл хүргэж ажиллалаа.



Шүүх байгууллагын нээлттэй, ил тод байдлыг хангах, иргэдэд мэдээлэл өгөх зорилгоор Хархорин сумын 8 байгууллагын 250 гаруй албан хаагчдад "Шүүхийн нээлттэй байдал, шүүхийн шийдвэрийн цахим санд нэвтрэх", "Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль" болон бусад мэдээллийг хүргэлээ. Харьяалах сумуудад байрлах мэдээллийн самбарын мэдээллийг улирал бүр шинэчлэн, иргэдэд хүргэж ажиллаж байна.



Хархорин сумын шуудан үйлчилгээний салбартай 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр хэрэг хүлээн авах, илгээх, хадгалах, тээвэрлэх зэрэг шуудангийн аюулгүй байдлын талаар нарийвчлан тусгасан шуудангийн үйлчилгээний гэрээг баталж,

шүүхээс явсан болон хүлээж авсан 945 хэрэг, баримт бичгийн үйлчилгээний зардалд 4144454 төгрөгийг зарцуулсан.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль болон Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлөөс баталсан дүрэм журмыг хэрэгжүүлэн эвлэрүүлэн зуучлалын ажиллагааг иргэн 2014 бүртгэл хяналтын нэгдсэн системийг хөтлөн ажиллаж байна. Харьяа сумдад 3 удаа нүүдэллэн ажиллаж тус сумдын сум хөгжүүлэх сан, малжуулах төсөл хариуцсан мэргэжилтнүүдэд болон багийн засаг дарга нарт эвлэрүүлэн зуучлах ажиллагааны талаарх сургалт, танилцуулгыг хийж, гарын авлага тараах материалыг өгч ажиллалаа.




2022 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн байдлаар шинээр 70 өргөдөл, урд оны үлдэгдэл 1 өргөдөлтэй бүгд 71 өргөдөл, 2 иргэний хэрэг бүгд 73 хэрэг, маргаан хүлээн авснаас 73 хэрэг, маргааныг шийдвэрлэсэн. Үүнээс 31 маргааныг эвлэрэл амжилттай болж, 13 хэрэг маргааныг эвлэрэл амжилтгүй болгож шийдвэрлэсэн.

“Шүүхийн иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулах, ажиллуулах журам”-ыг хэрэгжүүлэн 2022 онд 82 иргэдийн төлөөлөгч батлагдсанаас 37 иргэдийн төлөөлөгчид 9 удаагийн сургалт зохион байгуулж, хууль батлагдсантай холбоотойгоор шинээр гарын авлага бэлтгэж, иргэдийн төлөөлөгч нарт тарааж, иргэдийн төлөөлөгчийн 45.1 хувь нь сургалтад хамрагдлаа. Энэ онд 3 иргэн иргэдийн төлөөлөгчөөр хуралдаанд оролцсон.



Шүүхийн тамгын газраас 2022 оны 04 дүгээр сард 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрөөс 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацааны эрх зүйн акт, үйл ажиллагааг, шүүхийн Тамгын газрын даргын 2022.09.06-ны өдрийн А/24 дугаартай “Хяналт шалгалт явуулах комисс томилох тухай” тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг хэргийн хөдөлгөөний чиглэлээр 2 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдөр шүүгч, тамгын газрын албан хаагчдад танилцуулж алдаа зөрчлийг арилгах, хугацаа хоцролттой болон сайжруулах шаардлагатай ажил арга хэмжээг 4 дүгээр улиралд багтаан хийх хуваарь гарган хэрэгжилтийн явцыг хянаж ажиллалаа.



“Шүүхийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх журам”-д заасны дагуу 2022 оны 7 дугаар сарын 19-ний өдөр цахим талбарт тайланг гарган хүргүүлсэн. Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргын 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 232 дугаартай тушаалаар батлагдсан зарим анхан болон давж заалдах шатны шүүхийн тамгын газрын 2022 оны үйл ажиллагаанд аудит хийх удирдамжийн дагуу 2022 оны 10 дугаар сарын 31-ны өдрөөс 11 дүгээр сарын 01-ний өдрийн хугацаанд тус тус хяналт-шинжилгээ үнэлгээг биечлэн хийсэн. Тус хяналт-шинжилгээний үр дүнг албан хаагчдад танилцуулж, цаашид анхаарах асуудлууд, зөрчил гаргахгүй байх чиглэл өгсөн. Хяналт шалгалтад дүгнэлт хийж, Тамгын газрын дарга холбогдох албан хаагч бүрд хяналт шинжилгээ үнэлгээгээр гарсан зөрчлийг арилгах үүрэг даалгаврыг өгч, хяналт тавин ажиллаж байна. Тухайлбал:

Эрх зүйн актыг хугацаанд нь оруулж баталгаажуулах, шүүхийн гүйцэтгэх хуудсыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шийдвэр хүчин төгөлдөр болмогц гардуулах, эрүүгийн хэргийн эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн тэмдэглэлийг хүчин төгөлдөр болмогц Цагдаагийн Ерөнхий газарт хүргүүлэх, эд мөрийн баримтыг зүүлттэй хүлээж авах зэрэг үйл ажиллагаанд гарч байсан зөрчлийг арилгах арга хэмжээ авлаа.



Шүүхийн дотоод сүлжээний аюулгүй байдлыг ханган 3ш төхөөрөмжийг шинээр сольж, сүлжээний утаснуудад хаягжилт хийж, олон дамжлагат төхөөрөмжийн тоог багасган, сүлжээнд 16 хяналтын камер, 28 компьютер, бусад 4 төхөөрөмж холболттой байна.

Мэдээллийн технологийн чиглэлээр 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдөр сургалт зохион байгуулж, 20 шүүгч, албан хаагч, хэргийн хөдөлгөөний чиглэлээр ШЕЗ-өөс 03 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан “Шинээр батлагдсан дүрэм, журмууд” сургалтад 6 албан хаагч, шүүхийн тамгын газраас 10 дугаар сарын 17-ний өдөр хэргийн хөдөлгөөний чиглэлээр Шүүхийн ерөнхий зөвлөлөөс баталсан дүрэм журмуудаар дотоод сургалт зохион байгуулж 8 албан хаагч хамрагдан хэргийн хөдөлгөөний нэгдсэн систем ашиглах журам, эрүү болон иргэний хэргийн хөдөлгөөний нэгдсэн систем ашиглах журмын хэрэгжилтийн талаар тамгын газрын дарга Д.Долгормаа, мэдээлэл лавлагааны мэргэжилтэн Ж.Мөнхтуяа нар 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдөр шүүхийн захиргааны албан хаагчдын дунд хэлэлцүүлэг зохион байгууллаа.

ШЕЗ-өөс 2022 онд батлагдсан журмуудыг мөрдөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.



Шүүн таслах ажиллагааны сарын /11 удаа/, улирал тутмын /3 удаа/ мэдээ, хагас жилийн /1 удаа/ мэдээ тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь хүргүүлсэн.

2020-2021 оны эрүүгийн албан хэрэг хөтлөлт, эрх зүйн акт 9192 хуудас 108 хавтас баримтыг цахимжуулан эх хувийг холбогдох эрүүгийн хэргийн төв болон салбар архивт хүлээлгэн өгч, 2017-2021 оны иргэний хэргийн эрх зүйн

акт 22834 хуудас, 92 хавтас хадгаламжийн нэгжийг “Шүүхийн архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын журам”-д дагуу архивын баримтыг цахим хэлбэрт оруулсан.

Тус шүүхийн тамгын газрын архив нь “Иргэн, захиргааны хэргийн баримтын тусгай архивын ажлын заавар”, “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-д заасны дагуу шүүхийн тамгын газрын архивын баримтуудыг 3 хөмрөгт хуваан байнга, түр хадгалах хугацаагаар нь ангилан байрлуулсан.

“Иргэн, захиргааны хэргийн баримтын тусгай архивын ажлын заавар” шинэчлэгдэн батлагдсантай холбоотойгоор архивын хадгаламжийн нэгжийн бүртгэл, дансыг шинэчлэн бүртгэлжүүлэн ажиллаж байна.

Тус шүүхийн тамгын газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/02 дугаар тушаалаар “Баримт нягтлан шалгах комисс”-ыг өөрчилж комисс 2 удаа хуралдаж шийдвэр гаргасан. Архивын баримтын хадгалалтыг сайжруулан 3,6 сая төгрөгийн санхүүжилтээр нягтаршуулсан шүүгээ, чийгшүүлэх савыг шинэчилсэн.



Батлагдсан хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу эрүүгийн 98, иргэний 255, зөрлийн 395, шүүхийн шийдвэр биелүүлэхтэй холбогдон гарсан (хянан магадлан)-ийн 95 хэрэг хүлээн авч архивлалаа.

Дүн шинжилгээ:

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “Шүүхийн бие даасан байдлыг хангах чиглэл”-ээр 17 арга хэмжээ төлөвлөснөөс хэрэгжилт 92,3%-тай байна. ШЕЗ-өөс программыг ашиглалтад оруулаагүйгээс шүүхийн архивын мэдээлэл лавлагааны нэгдсэн системийн үйл ажиллагааг жигдрүүлэх төлөвшүүлэх ажил арга хэмжээ хийгдээгүй. Мөн гибрид шуудангийн тухай ойлголтыг орон нутгийн шуудан тасаг, албадын албан хаагч нарт нэгдсэн байдлаар өгөх, шүүхийн тамгын газартай хамтран ажиллах нөхцөл боломжийг бий болгох шаардлагатай байна.

2.2. ШҮҮХИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙГ УДИРДАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ:

Тус шүүх нь энэ онд 4 шүүгч, төрийн захиргааны болон үйлчилгээний 17 ажилтан албан хаагчтайгаар шүүх шүүхийн захиргааны үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулж байна. Шүүхийн тамгын газрын дарга шинээр томилогдон, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын сул 2 орон тоонд сонгон шалгаруулалт явуулах захиалга өгч 1 орон тоог журмын дагуу шилжүүлэн томилж, сул орон тоог нөхөж, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын сул орон тоонд сонгон шалгаруулалт явуулах захиалга өгч хүний нөөцийг бүрдүүлэхэд анхаарч ажиллаж байна.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг журмын дагуу 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр баталж, Хөдөлмөрийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдөр төрийн үйлчилгээний 9 албан хаагчийн “Хөдөлмөрийн гэрээ”-г шинэчлэн байгуулсан.



Шүүхийн тамгын газрын дарга 2022 оны 09 дүгээр сарын 02-ноос 09 дүгээр сарын 13-ны өдрүүдэд 9 албан хаагчийн албан тушаалын тодорхойлолт, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээний биелэлтийн явцыг хянаж, албан хаагч бүртэй ганцаарчилсан ярилцлага хийж, сайжруулах, эрчимжүүлэх хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллаж байна.



Шүүхийн хүний нөөцийн программд шүүгч, ажилтны цалин, нэмэгдэл цалин, зэрэг дэвийн өөрчлөлт, шагнал, сахилгын шийтгэл, ажлаас чөлөөлөгдсөн болон сэлгэсэн тухай мэдээллийг тухай бүр үнэн зөв оруулж байна.

Хархорин сум дахь Сум дундын шүүхийн үйлчлүүлэгчийн үйлчилгээний стандарт, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг хэрэгжүүлэх, албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах талаар албан хаагчдад нөлөөллийн ажил, ярилцлага хийж байна. Шүүхээр үйлчлүүлж байгаа иргэдээс улирал тутам сэтгэл ханамжийн судалгаа авахад

73,5 хувь нь хүссэн мэдээллээ авч чадсан, 65 хувь нь шүүхийн мэдээллийг фэйсбүүк болон цахим хуудаснаас авдаг гэж хариулсан нь өмнөх оны санал асуулгаас 3,5 хувиар өссөн байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан мэргэжлийн чиглэлийн болон бүсчилсэн сургалтад 12 албан хаагч, хуульчийн сонгон шалгаруулалтын шалгалтын сургалтад 3 албан хаагч, Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “7:4:10” вебинар 6 удаагийн сургалтад 50 гаруй албан хаагч хамрагдлаа.




Монгол бичгийн сургалтыг 7 хоног бүр зохион байгуулж албан хаагчид анхан болон дунд шатны мэдлэгтэй болсон.

Шүүгч, албан хаагчдыг урамшуулах, ажлыг үнэлэх зорилгоор төрийн дээд одон медаль, салбарын шагналд шагнуулахаар 6 албан хаагчийн холбогдох материалыг бүрдүүлэн Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлж, төрийн захиргааны 5 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулан олгосон байна.

Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх, баяжуулах ажлыг цаг тухай бүрд нь хийж байгаа бөгөөд ТАЗ-өөс 2022 оны 600 дугаартай тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу шинэчлэн 12 дугаар сарын 09-ний өдрийн дотор баяжуулалт хийсэн.

Хөдөлмөрийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг Тамгын газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/16 дугаартай тушаалаар баталсан.



Дүн шинжилгээ.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “Шүүхийн хүний нөөцийг удирдах чиглэл”-ээр 7 арга хэмжээ төлөвлөснөөс хэрэгжилт 100%-тай байна.

Сул орон тооны сонгон шалгаруулалтын захиалгыг сул орон тоо гарсан тухай бүр хүргүүлж байна. Хууль, журам зөрчиж томилсон зөрчил гараагүй болно. Монгол улсын шүүхийн тухай хуулинд заасны дагуу 2022 оны 03 дугаар сарын 01 -нээс эхлэн хуульчийн сонгон шалгаруулалтад тэнцэж гэрчилгээ авсан албан хаагчийг шүүгчийн туслахаар ажиллуулахаар заасан нь хүний нөөцийн асуудал хүндрэх магадлалтай байна. Тус шүүхэд ажилладаг шүүгчийн 3 туслахын 2 нь сонгон шалгаруулалтад тэнцээгүй. Хуульчийн сонгон шалгаруулалтыг ойрын хугацаанд зарлаж нөөц бүрдүүлэх шаардлагатай байна.

2.3. ШҮҮГЧИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫГ ХАНГАХ, ХУУЛЬ ЁСНЫ АШИГ СОНИРХЛЫГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ:

Шүүгчийн хараат бус, аюулгүй байдлыг хангах зорилгоор 2,8 сая төгрөгийн санхүүжилтээр тус шүүхийн 2 давхарт чиптэй хаалга суурилуулж, тандах багаж, аюулгүйн товчлуур авах хүсэлтээ холбогдох байгууллагад уламжилсан.



Шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, шүүхийн барилга байгууламжийн аюулгүй байдлыг хангах, шүүх хуралдааны танхимын дуу чимээг тусгаарлах зорилгоор тус шүүхийн эрүүгийн болон иргэний хэргийн шүүх хуралдааны танхимд давхар хаалгыг 1 сая төгрөгийн санхүүжилтээр шинээр суурилуулсан.

Өмнө нь:




Дараа нь:



Ажлын явц:



Шүүхийн тамгын газраас “Шүүгчийн хараат бус, аюулгүй байдал” сэдвээр видео шторк бэлтгэн 07 дугаар сарын 06-ны өдрөөс өөрийн www.kharkhorincourt.gov.mn цахим хуудас, <https://www.facebook.com/profile.php?id=100038379732418> фэйсбүүк хуудас болон “Хархорин шүүх” youtube сувгаар нийтэлж, 2000 гаруй иргэнд, шүүгчийн хараат бус байдалд халдахаас сэргийлэх чиглэлээр гарын авлага, брюшурыг 340 гаруй иргэнд хүргэлээ.




Шүүхийн ерөнхий зөвлөлөөс бэлтгэн гаргасан 182 төрлийн шторк, видео танилцуулгуудыг шүүхийн үйлчилгээний хэсгийн дэлгэцээр иргэдэд мэдээлж байна.

Хархорин сум дахь сумдын шүүх, сум дундын цагдаагийн хэлтсийн 2022 оны хамтран ажиллах төлөвлөгөөг 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдөр батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Ерөнхий шүүгч Б.Сарантуяа, тамгын газрын дарга Д.Долгормаа нар 2022 оны 08 дугаар сарын 02-ны өдөр шүүхийн харуул, хамгаалалтын цагдаа, шүүхийн дэг сахиулагч цагдаа нарт “Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах журам”-аар сургалт зохион байгуулж, сахилга хариуцлага, дэг журмыг дээшлүүлэх талаар үүрэг чиглэл өгч, цагдаагийн ахлагч Б.Батчулуун шүүгчийн аюулгүй байдлыг хангах, бие хамгаалах тусгай хэрэгслийн ажиллагааг 2022 оны 02 дугаар сард шалган заавар зөвлөмж өгч ажилласан.



Шүүгч нарт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар гарын авлага бэлтгэн тарааж, шүүгчид хориглох зүйл, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр мэдээлэл хийж, тайланг ШЕЗ-д хүргүүлсэн.



Тус шүүхийн Тамгын газраас 04 дүгээр сарын 06-ны өдөр шүүгч нарын ар гэрийнхэнтэй цахимаар уулзалт зохион байгуулж, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах журам, хуулийн заалтуудаар сургалт зохион байгуулж, санал солилцсон.



Дүн шинжилгээ:

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “Шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэл”-ээр 12 арга хэмжээ төлөвлөснөөс хэрэгжилт 98.7%-тай байна. Цагдаагийн хэлтэстэй хамтран ажиллах төлөвлөгөөнд ач холбогдол өгч, байгууллагын удирдлага, холбогдох албан хаагчдыг маш сайн уялдаа холбоотой ажиллуулж, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, шүүхэд эмх замбараагүй байдал үүссэн үед авах арга хэмжээг нарийвчлан тусгах, дадлага сургууль хийх шаардлагатай байна.



Шүүгч, түүний гэр бүлийн гишүүнд аюул занал учирсан тохиолдолд хамгаалалтын арга хэмжээг авах, өөрийгөө хамгаалах дадлага сургалт хийхээр тус төлөвлөгөөнд тусгаж мэдээллээр хангах шаардлагатай.

2.4. ШҮҮХИЙН САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

2.4.1. Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Сангийн сайдын 190 тоот тушаал, бусад холбогдох хууль, журмыг хэрэгжүүлэн 2022 оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, өр авлага үүсгэхгүй ажиллаж байгууллагын хэмжээнд хэмнэж болох гэрэл, цахилгаан, шатахуун, бичиг хэргийн зардлыг хэмнэж ажиллаж байна.

Төсвийн тухай хуулийн 8.9.1 заалтыг хэрэгжүүлж 1,2,3-р улирлын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд Э-Тайланд шивж цаасан тайланг төсвийн ерөнхийлөн захирагчид төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8.1 дэх заалтыг хэрэгжүүлж сарын гүйцэтгэлийн мэдээг 11 удаа хуулийн хугацаанд мэйлээр хүргүүлсэн.

Өмч хамгаалах байнгын зөвлөлийг тамгын газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/29 тоот тушаалаар шинэчлэн байгуулж, үндсэн хөрөнгө, ажил, үйлчилгээ төсвийн хөрөнгөөр худалдан авах, өмч шилжиж ирэх, үндсэн хөрөнгийг актлах, хугацааг нь сунгах, хагас жилийн тооллого хийх зэрэг асуудлаар зөвлөл тухай бүр хуралдан шийдвэр гарган ажиллаж байна.



Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн нийт 133 мэдээллийг хуулийн хугацаанд нь үнэн зөв оруулсан.

Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу цалин хөлсийг үнэн зөв тооцоолж, урьдчилгаа болон үндсэн цалинг 23 удаа бодож олгон, тайлан гаргасан байна.

Дүн шинжилгээ:

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “Шүүхийн санхүү эдийн засгийн баталгааг хангах чиглэл”-ээр 7 арга хэмжээ төлөвлөснөөс хэрэгжилт 100%-тай байна. Шүүхийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулан, өр авлага үүсгэлгүй ажиллалаа.

Шүүхийн захиргааны үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай компьютер, принтер, ширээ, сандал, сейф, шүүгчийн туслах, мэдээлэл лавлагааны мэргэжилтний ажиллах нөхцөлийг сайжруулах, иргэдийн нууцлалыг хангахтай холбогдуулан шилэн хаалт хийх, шүүх хуралдааны явцыг дуу дүрсний бичлэгээр баталгаажуулах камер, серверийн өрөөний сэнс, тог баригч, цахилгаан үүсгүүр шаардлагатай тул судалж, санхүүжилтийг шийдвэрлэж өгөх саналтай байна. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “Мэдээллээр хангах чиглэл”-ээр 3 арга хэмжээ төлөвлөснөөс хэрэгжилт 100%-тай байна.

2.5. МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

Шүүхээр шийдвэрлэсэн хэргийн тойм мэдээллийг сар, улирлаар, шүүхийн болон Тамгын газрын үйл ажиллагааны талаарх 197 мэдээ мэдээллийг шүүхийн www.kharkhorincourt.gov.mn цахим хуудас, фэйсбүүк хуудсаар дамжуулан 19000 гаруй иргэнд хүргэсэн.

Шүүхийн шийдвэрийн цахим санд эрүүгийн хэргийн 115 шийтгэх тогтоол, иргэний хэргийн 19 шийдвэрийг журмын дагуу байршуулж, шүүхийн шийдвэрийн тойм мэдээг өөрийн шүүхийн сайтаас авах боломжтойгоор live.shuukh.mn сайтын “Шүүх хуралдааны тойм” хэсэгтэй холбон байршууллаа.

Дүн шинжилгээ:

2022 онд www.kharkhorincourt.gov.mn цахим хуудсанд сар тутмын мэдээ болон улирлын, хагас, бүтэн жилийн мэдээ, шүүхийн цаг үеийн мэдээ мэдээллийг шүүхийн болон тамгын газрын, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны фэйсбүүк, цахим хуудаст 197 удаагийн мэдээллийг байршуулан 19000 гаруй иргэнд хүргэсэн. Цаашид байгууллагын сайтын хэрэглэгчийн тоог нэмэх, мэдээний агуулга, чанар, хүртээмжид анхаарах, тамгын газраас эрхлэн гаргадаг Шүүхийн мэдээлэл сонины уншигчийн тоог нэмэх шаардлагатай.

2.6. БУСАД АЖИЛ

1. 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр Монгол улсад Ардчилсан Үндсэн хууль батлагдсаны түүхт 30 жилийн ойг тохиолдуулан шүүхийн захиргааны албан хаагчдын дунд "АХА" тэмцээн, шүүгч, албан хаагчдын дунд "Дартс"-ны тэмцээн зохион байгуулсан.





2. 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр Уламжлалт анагаах ухааны их эмч Э.Молор-Эрдэнэ тус шүүхийн шүүгч, албан хаагчдад "Уламжлалт анагаах ухааныг түгээн дэлгэрүүлэх" сэдэвт танин мэдэхүйн лекц танилцуулга хийж, үнэгүй эрүүл мэндийн үзлэг оношилгоо хийлээ.

3. 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдөр Шүүхийн Тамгын газар болон тус сумын Онцгой байдлын хэлтэстэй хамтран болзошгүй аюулт үзэгдэл, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор "Галын аюулгүй байдал" сэдвээр танхимын сургалт, галын аюулгүй байдлын тархалтын сургалтыг зохион байгуулсан.



4. 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдөр Шүүхийн тамгын газрын дэргэд тус шүүхийн шүүгч, албан хаагчдын гэр бүлийн гишүүдээс бүрдсэн "Гэр бүлийн зөвлөл"-ийг энэ оны 01 дүгээр сард байгуулж, төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллалаа.

5. "Хүүхдээ сонсох өдөр"-ийг 2022 оны 03 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулж аав ээжийнх нь ажлын онцлог, шүүхийн байгууллагын талаар танилцуулж, хүүхдүүдийн саналыг сонслоо.



6. Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Сум дундын шүүхийн тамгын

газар, 1 дүгээр багаас 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдөр Архангай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч Т.Даваасүрэнг урьж, “Дурсамж уулзалт”-ыг зохион байгуулсан.



7. Шүүгч, ажилтнуудыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, спортоор хичээллэн бие бялдраа хөгжүүлэх чийрэгжүүлэх зорилгоор спорт заалтай гэрээ байгуулан долоо хоног бүрийн Лхагва гарагт гар бөмбөг, сагсан бөмбөгийн спортоор хичээллэж байна.

8. Монголын Шүүгчдийн холбооны Хархорин салбар хороо, Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын шүүхийн тамгын газраас санаачлан "Монгол өрх" сэтгэл зүйн хүрээлэнгийн захирал С.Баасанбатыг урьж 2022 оны 03 дугаар сарын 31-нд "Хүний хөгжил, сэтгэл зүйн дархлаа" сэдвээр сургалт зохион байгууллаа. Сургалтад тус шүүхийн тамгын газар, Хархорин сум дахь сум дундын прокурорын газар, Хархорин сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэс, Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь ШШГХэлтэс, 423 дугаар нээлттэй хаалттай хорих ангийн 150 гаруй алба хаагч хамрагдсан.



9. "Дэлхийн номын өдөр"-ийг тохиолдуулан 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр Хархорин сумын соёлын төвтэй хамтран "Гэр бүлийн өдөрлөг" нэртэйгээр зохион байгуулсан.



10. Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, орон нутгийн соёл, хууль сахиулах байгууллага, соёлын өв хамгаалагч нарын хамт ажиллагааг сайжруулах зорилгоор Өвөрхангай аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хамтран зохион байгуулж буй "Өв хамгаалагч" аяны хүрээнд 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Өвөрхангай аймгийн Хархорин сумын Ганган Орхон багийн Ар модны дэнж хэмээх газарт байрлах "Тахилын онгон хиргисүүр"-ийг хашаажуулах, засварлах ажилд оролцсон.



11. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг дэмжин хот хоорондын зам дагуу 200 гаруй хайлаас мод, байгууллагын эзэмшил газрын 250 мкв талбайд зүлэгний үр, 5 гацуур, 10 агч мод тарьсан.



12. Хангайн бүсийн шүүхийн шүүгч, ажилтнууд оролцсон "ХАНГАЙН БҮС-2022" спортын наадамд багийн дүнгээр 3 дугаар байр эзэллээ.



13. Монгол төрийн цагдаагийн байгууллага үүсэж хөгжсөний түүхт 101 жил, Дотоодын цэргийн 100 жил, Хархорин сум дахь Сум дундын Цагдаагийн хэлтэс байгуулагдсаны 50 жилийн баярыг тохиолдуулан 2022 оны 07 дугаар сарын 19-ний өдөр Хархорин сум дахь Сум дундын шүүхийн тамгын газраас шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хамгаалан ажилладаг хамгаалалтын болон харуулын цагдаа нарт 2022 оны 07 дугаар сарын 19-ний өдөр хүндэтгэл үзүүллээ.



14. Шүүхийн тамгын газраас шүүгч, албан хаагчдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-г 2022 оны 07 дугаар сарын 28-ны өдөр баталж хэрэгжилт 90%-тай байна.

15. Байгууллага дээр номын сантай болох, ном хандивлах аяныг зохион байгуулж мэргэжлийн болон хууль эрх зүй, хүүхдийн, уран зохиол, шинжлэх ухаан, хувь хүний хөгжил, ур чадвар гэсэн 6 төрлийн 200 гаруй номтой болж, албан хаагчид чөлөөт цагаа зөв өнгөрөөх, мэдээлэл авч, мэдлэг нэмэгдүүлэх боломж бүрдсэн.



16. Ахмадын баярын өдрийг тохиолдуулан Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Сум дундын шүүхийн тамгын газраас 09 дүгээр сарын 30-ны өдөр тус шүүхэд 13-26 жил ажилласан ахмад настан Г.Норлохсүрэн, Х.Нарантуяа нарт хүндэтгэл үзүүлэх уулзалтыг зохион байгуулсан.

17. Тус шүүхийн тамгын газар "Эрдэнийн толь" эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээний хүрээнд албан хаагчдаа урьдчилан сэргийлэх шинжилгээнд хамруулж, тус эмнэлгийн эмч Г.Дүншиг албан хаагчдад хэвлийн хөндий, эмэгтэйчүүдийн хэт авиан шинжилгээ хийж, зөвлөгөө өглөө.



18. Байгууллагын шүүгч, албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор "Хуримтлалын сангийн журам"-ыг хэлэлцүүлэн баталж, хамт олны хурлаас сангийн зохицуулагчдыг томилон, сангийн бүрдүүлэлт зарцуулалтад хяналт тавин ажиллаж байна.

ӨВӨРХАНГАЙ ДАЙМГИЙН ХАРХОРИН СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ЦУГАЧ, АЛБАН ХААГЧДЫН ОНЫ 19 ДУГААР САРЫН 12-НЫ ӨДРИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦЭН БАТЛАВ.

ХАРХОРИН СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН
АЛБАН ХААГЧДЫН ХУРИМТЛАЛЫН САНГИЙН ЖУРАМ

НЭГ. Зорилго

Хархорин сум дахь Сум дундын шүүхийн тамгын газрын албан хаагч, ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, амралт чөлөөт цагаа зөв өнгөрүүлэх, харилцан бие биедээ тусалж эерэг хандлага бий болгох, хамт олны төлөвшил, нийтэч байдлыг дэмжих зорилгоор санхүүгийн хуримтлал бий болгож, "Хуримтлалын сан" /цаашид сан гэж/ байгуулах, сангийн хөрөнгийг зөв зохиистой зарцуулах, хяналт тавих, тайлагнах харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. Сангийн орлогын эх үүсвэр

2.1 Албан хаагчдын цалингаас сар бүр тогтоосон хэмжээгээр суутгасан хураамж /Сар бүр 30 000 төгрөг /

2.2 Хамт олноороо нийгмийн тустай хөдөлмөрт оролцож хуримтлуулсан орлого /Ажлын бус цагаар хамт олон хүсвэл сангийн хөрөнгийг арвижуулах зорилгоор орлого олох аж ахуйн үйл ажиллагаа явуулж болно. /

ГУРАВ. Сангийн ажиллах журам

3.1 Сангийн зохицуулагчдыг байгууллагын нийт албан хаагчдын хурлаас 3 хүний бүрэлдэхүүнтэй сонгоно.

3.2 Сонгогдсон 3 гишүүн дотроосоо ахлагчаа сонгоно.

3.3 Сангийн ахлагч сангийн орлогыг бүрдүүлэх, зарцуулахад анхаарч хяналт тавьж ажиллана.

3.4 Бүх албан хаагчид сар бүр мөнгөө санд төвлөрүүлэх үүрэг хүлээнэ.

3.5 Сангийн хөрөнгийг дор дурдсанаас өөр зүйлд зарцуулахыг хориглоно.

Дөрөв. Сангийн хөрөнгийн зарцуулалт

4.1 Нийтийг хамарсан амралт, аялал зугаалгад 3 000 000 төгрөг хүртэл

4.2 тэмдэглэлт баяр ёслолд 200 000 төгрөг хүртэл

4.3 Туршлага судлах, аймаг, бүсийн тэмцээнд оролцоход 500 000 төгрөг

4.4 Сумын уралдаан тэмцээнүүдэд оролцоход 200 000 төгрөг хүртэл /жилд 2 удаа/

4.5 Албан хаагч шинэ хүүхэдтэй болоход 200 000 төгрөг

4.6 Ажилтан өөрөө хуримлах, шинэ орон сууцанд ороход 1 000 000 төгрөг

4.7 Үр хүүхэд нь гэрлэх болон шинэ орон сууцанд ороход 500 000 төгрөг

4.8 Хүүхдийн савлаг үргэхэд 300 000 төгрөг /өөрийн хүүхэд болон өч, зээ хамаарна/

ГУРАВ. НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, АЖИЛ САЙЖРУУЛАХ САНАЛ

Тус шүүхийн тамгын газар 2022 оны үйл ажиллагаагаа байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээтэй уялдуулан зохион байгуулан ажиллаж байна.

Монгол улсын шүүхийн тухай хууль болон ШЕЗ-өөс баталсан журмуудыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан уншиж, судлах, хөрсөн дээр буулгах, хэвшүүлэх зайлшгүй шаардлага урган гарч байна. Албан хаагчдадаа ажлын байран дээр сургах, хууль дүрэм журмыг бие дааж судлах, холбогдох хууль, журмыг танилцуулсан сургалт зохион байгуулж чадавхижуулахад анхаарч ажиллалаа.

Иргэдийн шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, шүүх байгууллагын нээлттэй, ил тод байдлыг хангах, шүүхэд мэдүүлэх эрхийг нь таниулах, хүүхэд багачуудыг гэмт хэрэгт оролцохоос урьдчилсан сэргийлэх нөлөөллийн ажил зохион байгуулах, нөгөө талаас албан хаагчдаа уншдаг, судалдаг, илтгэдэг болгох зорилгоор багийн зохион байгуулалтад орж сургалтын материал бэлтгүүлэн төрийн албан хаагчид, ЕБС-ийн дунд ахлах ангийн сурагчдад сургалт зохион байгуулах хуваарь гарган хэрэгжүүлж ажилласан нь талархал хүлээсэн ажил боллоо.

Хүн бүр цахим хэрэглээтэй болсонтой холбогдуулан шүүхийн үйлчилгээг цахимаар иргэд авах, цахимаар мэдээлэл хүргэхтэй холбогдуулан байгууллагын сайтад мэдээлэл лавлагаа, улсын тэмдэгтийн хураамж төлөх, хэрэг хуваарилах

журам, цахим хүсэлт өгөх зэрэг цэсийг шинээр нээлээ. Иргэдээс авсан санал асуулгаар иргэдийн цахимаас тодорхой мэдээллээ авах байдал нэмэгдсэн гэсэн дүгнэлт бий болж байна. Шүүхийн тамгын газраас улирал тутам эрхлэн гаргадаг “Шүүхийн мэдээлэл” сэтгүүлийн агуулгад анхаарч хэвлэлийн тоог нэмэгдүүлэн, цахим хэлбэрээр унших боломжтой боллоо.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр улирал тутам төлөвлөгөө гаргаж ажилласан нь хэрэгжилтийг хангах, явцыг хянах, удаашралтай, хугацаа хоцорсон, эрчимжүүлэх шаардлагатай ажил арга хэмжээг дараагийн улиралд гүйцэтгэх, албан хаагчид хариуцлагатай болох, үр дүнг тухай бүр тооцох ач холбогдолтой байлаа.

Шүүн таслах ажиллагаа тасралтгүй хэвийн явагдсан боловч шүүх хуралдааны явцыг дуу, дүрс бичлэгээр баталгаажуулах төхөөрөмж ажиллахгүй, одоо хэрэглэж байгаа гар камер шаардлага хангахгүй байгаа хүндрэл гарч байна. Энэ тухай ШЕЗ-д албан бичгээр удаа дараа хүргүүлсэн боловч шийдэгдэхгүй байгааг анхаарна уу.

Шүүгчийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан аюулгүйн товчлуур, хэргийн оролцогч шүүгдэгчийг хуралдаанд орохоос өмнө согтуурал хэмжих тандах багаж, сүлжээ сарниулагч, металл илрүүлэгч зэрэг багаж төхөөрөмжөөр хангах, санхүүжилтийг шийдвэрлэх шаардлагатай байна.

Байгууллагын архивыг цахимжуулах хурдны сканнер байхгүй, худалдан авах төсөвгүйгээс энэ ажил зогссон тул үүнийг шийдвэрлүүлэх саналтай байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХАРХОРИН СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН Д.ДОЛГОРМАА